



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 21 өдөр

Дугаар А/40

Өвт

Хамгаалалтын зурвас тогтоох тухай


Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалт, Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн 2.2, 2.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын эрчим хүчний шугам, сүлжээний аюулгүй ажиллагааг хангах, засвар үйлчилгээг саадгүй явуулах хүн, мал амьтан осолдохоос урьдчилан сэргийлэх зорилгоор цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын хамгаалалтын зурвасыг хавсралтаар баталсугай.

2. Хамгаалалтын зурвас тогтоох явцад хяналт тавьж ажиллахыг “Эрдэнэт Булган цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компаны Хархорин салбар Бат-Өлзий хэсгийн техникч /Д.Мөнх/ Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даамал /И.Маралмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн “Хамгаалалтын зурвас тогтоох тухай” А/152 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН

622,03084

ХАМГААЛАЛТЫН ЗУРВАС

№	Шугам сүлжээний ангилал	Хамгаалалтын зурвасын хэмжээ	
		Цахилгаан дамжуулах агаарын шугам шугамын захын утаснаас хоёр тийш	дэд станц тал бүр тийш
1	1-20 хүртэл кВ	2 метр	10 метр
2	35 кВ	4 метр	15 метр

-оОо-